



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/96

Бат-Өлзий сум


Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
сунгах тухай


Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Т.Нямсүрэн эзэнтэй “Мөнх-Ундарга”, Х.Нямлхагва эзэнтэй “Оргил”, Н.Алтансүх эзэнтэй “Энэ” хүнсний дэлгүүрүүдийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (Нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, (Д.Энх-Амгалан Цагдаагийн ахмад), Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч (М.Мягмаржав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С АМГАЛАН



022209191

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/